

# I-V ангийн зөв бичих чадварын агуулгын залгамж холбоо

Анги	1-р анги	2-р анги	3-р анги	4-р анги	5-р анги
<b>БИЧИХ ЧАДВАР</b>					
Бичих чадварт тавигдах шаардлага	Үсгийг зурлагын дагуу зөв бичих, үг холбон, өгүүлбэрийг том үсгээр бичих	Үг холбон, өгүүлбэрийг том үсгээр эхлэн бичих, өгүүлбэр, эхийг бүтцийн дагуу хичээнгүй алдаагүй зөв бичих	Үг холбон, өгүүлбэрийг том үсгээр эхлэн бичих, өгүүлбэр, эхийг бүтцийн дагуу хичээнгүй алдаагүй зөв бичих	Үг холбон, өгүүлбэрийг том үсгээр эхлэн бичих, өгүүлбэр, эхийг догол мөрөөр зааглан, дэгийн дагуу хичээнгүй алдаагүй зөв бичих	Үг холбон, өгүүлбэрийг том үсгээр эхлэн бичих, өгүүлбэр, эхийг догол мөрөөр зааглан, дэгийн дагуу хичээнгүй алдаагүй зөв бичих
Зөв бичих	1.2.а. Хуулж болон цээжээр бичихдээ үсэг, үг, өгүүлбэрийг дэгийн дагуу бичих	2.2.а. [н,г] үсгээр утга ялгаж үгсийг зөв унших, нүдлэх, зөв бичих	"3.2а. Утга ялгасан үгийг /н,г,х/ зөв дуудах, нүдлэх, өгүүлбэрт утга ялган зөв хэрэглэх"	4.2а. Дуудлага ижил зарим үгийг утга, бичлэгээр нь ялгах өгүүлбэрт зөв бичих (буурь-буйр, хууль-хуйл, тууль-туйл)	5.2а. Залгавар залгахад эгшиг гээгдэх, гээгдэхгүй тохиолдлыг мэдэж, бүлэглэх, тайлбарлах
	1.2.б. Хүний нэр ба өгүүлбэрийг том үсгээр эхлэн бичих, өгүүлбэрт цэг, таслал, асуултын тэмдгийг зөв хэрэглэх	2.2.б. Эр, эм үг үгэнд "ы, ий" залгаврыг зөв залган бичих	"3.2б. . Балархай эгшгийн эгшигжүүлэх үүргийг мэдэх, бичихдээ хэрэглэх"	4.2б. Балархай эгшгийн эгшигжүүлэх, зөөлрүүлэх үүргийг мэдэх, зөв бичих	5.2.б. Үйл үг бүтээх "-л" дагаврын дүрмийг мэдэж, зөв бичих
		2.2.в. Үгийг үеэр таслан мөр шилжүүлж зөв бичих	"3.2в. Дараалсан гурван гийгүүлэгчийн дүрмээр зөв бичих"	4.2в. ж, ч, ш-ийн дараа "и" бичдэгийн учрыг мэдэх, зөв бичих	
		2.2.г. Цагаан толгойн үсгийг эгшиг, гийгүүлэгч, тэмдэг үсэг гэж ангилж, бүлэглэх	3.2г. Газар ус, улс орон зэрэг оноосон нэрийг ялгах, зөв бичих	4.2г. Хатуу, зөөлний тэмдгийн тусгаарлах үүргийг мэдэж, зөв бичих	



Сурагчийн нэр: ..... Эхэлсэн: ..... он ..... сар ..... өдөр.....цаг

**Балархай эгшиг**



**гээгдэх тохиолдол**

- ❑ Балархай эгшиг нь үгэнд нэг үүргээр орсон бол гээгдэнэ.
- ❑ И-гээс бусад богино эгшгээр төгссөн үгэнд урт эгшгээр эхэлсэн залгавар залгахад төгсгөлийн балархай эгшиг гээгдэнэ.

**гээгдэхгүй тохиолдол**

- ❖ Балархай эгшиг нь үгэнд хоёр үүргээр орсон бол гээгдэхгүй.
- ❖ Оноосон нэрийн балархай эгшиг гээгдэхгүй

7 - эгшигт 7 гийгүүлэгч

$7+7=Э$

Э - эгшигтэй

эгшигт гийгүүлэгч: м,н, г, л, б, в, р

1 А. Загварт тохирох дараах үгсийг ажиглаарай. Балархай эгшиг хэдэн үүргээр орсныг цэгийн оронд нөхөж бичээрэй.

Б. Урт эгшгээр эхэлсэн залгавар залган бичээрэй.

$7+7=Э$

намар, савар,  
гэрэл, төмөр, өвөл

$9+7=Э$

өдөр, сүүдэр, газар,  
аадар, шүүдэр

$9+9=Э$

модод, хүүхэд,  
амьтад, нөхөд,

А. Балархай эгшиг нь ..... үүргээр орсон байна

Б. *намрын*

---



---



---

И-гээс бусад богино эгшгээр төгссөн үгэнд урт эгшгээр эхэлсэн залгавар залгахад төгсгөлийн балархай эгшиг гээгдэнэ.

2 А. Богино эгшгээр төгссөн үгийг олж будаарай.

Б. Урт эгшгээр эхэлсэн залгавар залган бичээрэй.

А. хурга    өвөл    үзэг    хана    шөнө    ширээ    ботго

Б.

---



---



Сурагчийн нэр: ..... Эхэлсэн: ..... он ..... сар ..... өдөр.....цаг



**Балархай эгшиг**

**гээгдэх тохиолдол**

- ❑ Балархай эгшиг нь үгэнд нэг үүргээр орсон бол гээгдэнэ.
- ❑ И-гээс бусад богино эгшгээр төгссөн үгэнд урт эгшгээр эхэлсэн залгавар залгахад төгсгөлийн балархай эгшиг гээгдэнэ.

**гээгдэхгүй тохиолдол**

- ❖ Балархай эгшиг нь үгэнд хоёр үүргээр орсон бол гээгдэхгүй.
- ❖ Оноосон нэрийн балархай эгшиг гээгдэхгүй

1 А. Загварт тохирох дараах үгсийг ажиглаарай. Балархай эгшиг хэдэн үүргээр орсныг цэгийн оронд нөхөж бичээрэй.

Б. Урт эгшгээр эхэлсэн залгавар залган бичээрэй.

**7+7=Э** самбар, бамбар, тэнгэр, бөмбөр, олбог,

самбарын

.....гийгүүлэгчийг эгшигжүүлэх үүргээр орсон байна.

Үгийн дунд орсон ялгах эгшиг хоёр үүрэгтэй тул гээгдэхгүй.

2 А. Үгсийг ажиглаад, балархай эгшгийн үүргийг тэмдэглээрэй.

Б. Урт эгшгээр эхэлсэн залгавар залган бичээрэй.

А. чанар, тугал, хоног, үнэг, шагнал, онол, хотгор, хоргол, аргал

Б.

Оноосон нэрийн балархай эгшиг гээгдэхгүй.

3 А. Оноосон нэрийг олж будаарай.

Б. Урт эгшгээр эхэлсэн залгавар залган бичээрэй.

А. Төмөр дэвтэр Орхон гол Гэрэл гэрэл Дархан хавар

Б.



Сурагчийн нэр: ..... Эхэлсэн: ..... он ..... сар ..... өдөр.....цаг

Эгшгээр төгссөн үгэнд “- л” дагаврыг шууд залган бичнэ.

1 Юу? гэсэн асуултад хариулагдах эгшгээр төгссөн үгийг ялган бичээрэй.





тоо, сум, бод,  
хүрээ, дуу, багц,  
цэцэг, тариа

---

---

---

2 “- л” дагаврыг зөв залган бичээрэй.



Эгшигт гийгүүлэгчээр төгссөн үгэнд үйл үг бүтээх “- л” дагавар залгахдаа эгшгийг ард нь бичнэ.

3 А. Эгшигт гийгүүлэгчээр төгссөн үгийг олж будаарай.

Б. “- л” дагаврыг залган бичээрэй.

- А. цэцэг, шоо, ус, амт, нэр, заавар,  
баяр, баг, мэх, тух, анги, сав

Б.

---

---

Заримдаг гийгүүлэгчээр төгссөн үгэнд үйл үг бүтээх “л” дагавар залгахдаа эгшгийг өмнө нь бичнэ.

4 А. Заримдаг гийгүүлэгчээр төгссөн үгийг олж будаарай.

Б. “- л” дагаврыг залган бичээрэй.

- А. цаас, хээ, ус, нэр, нэр, алд,  
цоож, баг, мэх, багц, анги, сав

Б.

---

---



Сурагчийн нэр: ..... Эхэлсэн: ..... он ..... сар ..... өдөр.....цаг



Эгшигт гийгүүлэгчээр төгссөн үгэнд –л дагаврыг залгахдаа зохих балархай эгшгийг ард нь бичнэ

тагла, бөглө, нэрлэ, ажилла, амла, сумла

Заримдаг гийгүүлэгчээр төгссөн үгэнд –л дагаврыг залгахдаа зохих балархай эгшгийг өмнө нь бичнэ

дансал, багцал, борцол, бутал

Эгшгээр төгссөн үгэнд –л дагаврыг шууд залгаж бичнэ.

тоол, төөл, цайл, хөөл

### 1 Харьцуулан ажиглаарай.

тоо

юу? нэр үг

тоол

+л

яха? үйл үг

цүнх

+л

юу? нэр үг

цүнхэл

яха? үйл үг

### 2 Дараах үгсийг ажиглаад эгшгээр төгссөн бол ■ эгшигт гийгүүлэгчээр төгссөн бол ■ заримдаг гийгүүлэгчээр төгссөн бол ■ өнгөөр будаарай.

- баяр, шоо, үнэ, лааз, нэр, дарш
- ном, хээ, мэх, тух, анги, баг

### 3 Дээрх үгсэд “л” дагаврыг залган бичээрэй.

---



---

### 4 Зөв харгалзуулаарай.

- ангил
- сумла
- багцал
- ирлэ
- товчил

Э.Г-ээр төгссөн үгэнд “л” дагавар залгасан

З.Г-ээр төгссөн үгэнд “л” дагавар залгасан

Эгшгээр төгссөн үгэнд “л” дагавар залгасан

- савла
- хээл
- даршил
- тухал
- ундаал

### 5 Дараах өгүүлбэрийн хоосон зайд “-л” дагаврыг залган бичээрэй.

Бусдын асуултад тод дуугаар хариу\_\_ ж байгаарай.  
 Эвэрт цох, төөлүүр болон шавжаар хоол\_\_но.  
 Морио суран ногтоор ногт\_\_но.